



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/431

Булган сум

Баяр наадмын хугацаанд өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, Нийтээр тэмдэглэх болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын удирдлага, аймгийн Морин спорт, уяачдын холбоо, Үндэсний бөхийн холбооны саналуудыг үндэслэн Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын 104 жилийн ойн Булган аймгийн баяр наадмыг 2025 оны 07 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд, түүхт болон тэмдэглэлт ой нь тохиож байгаа Баян-Агт, Орхон сум, Хялганат тосгоноос бусад сумдын баяр наадмыг 2025 оны 07 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгуулахаар наадмын хугацаанд өөрчлөлт оруулсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/372 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР